



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**БАЯНТҮМЭН, ХӨЛӨНБУЙР, СЭРГЭЛЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН 2 НАМЫН 7 НЭР ДЭВШИГЧИЙН
ЗАРДЛЫН ДАНСАНД ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЛГЭЭ ХИЙГДЭЭГҮЙ,
МӨНГӨН БОЛОН МӨНГӨН БУС ХАНДИВ АВААГҮЙ БАЙНА.**

**ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМ, ЭВСЭЛ,
НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ, НИЙТЭД МЭДЭЭЛЭХ**

АУДИТЫН КОД: ДОА-2022/19-5-НА-СТА

Чойбалсан хот 2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuub@audit.gov.mn
Аудитор Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: Ouyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

| | |
|--|---|
| Товчилсон үгийн тайлбар | 2 |
| Хүснэгтийн товъёг..... | 3 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл | 4 |
| Үндсэн мэдээлэл | 5 |
| Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын талаар | 5 |
| ДҮГНЭЛТ: | 7 |
| ЗӨВЛӨМЖ: | 7 |
| ТУШААЛ: | 8 |



Товчилсон үгийн тайлбар

| | |
|-----|------------------------------|
| АН | Ардчилсан нам |
| ДОА | Дорнод аймаг |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| МАН | Монгол ардын нам |
| НА | Нотлох аудит |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |



Дүрслэлийн товьёг

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|-----------|---|-----------------|
| Хүснэгт 1 | Орон нутгийн ИТХ-ын нөхөн сонгуульд нэр дэвшигчид | 5 |
| Дүрслэл 1 | Орон нутгийн ИТХ-ын нөхөн сонгуульд оролцогч намуудаас нэр дэвшигчдийн эзлэх хувь | 5 |
| Хүснэгт 2 | Орон нутгийн Хурлын нөхөн сонгуулийн зардлын данс нээлгээгүй нэр дэвшигчид | 5 |
| Хүснэгт 3 | Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны орлого | 6 |



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.5 дахь заалт Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2020 оны 23 дугаар тушаалыг тус тус үндэслэн Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумдын ИТХ-ын нөхөн сонгуульд оролцож байгаа нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажуулсан.

Аудитын зорилт

Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумдын ИТХ-ын нөхөн сонгуульд оролцож байгаа нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж дүнг нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумдын ИТХ-ын нөхөн сонгуульд оролцож байгаа нам, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтээ хуулийн дагуу бүрдүүлсэн эсэх.
- ✓Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумдын ИТХ-ын нөхөн сонгуульд оролцож байгаа нам, нэр дэвшигч сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх.
- ✓Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумдын ИТХ-ын нөхөн сонгуульд оролцож байгаа нам, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг баримталсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Дорнод аймгийн Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумын ИТХ-ын нөхөн сонгуульд оролцож байгаа 2 нам, 7 нэр дэвшигчийн ирүүлсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай материалуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн хүрээнд MNS 6817 : 2020 төрийн аудитын стандартын дагуу гүйцэтгэнэ. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, нэгтгэх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулан тайланг бэлтгэв.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, 1-р багийн ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Одхүү, Б.Оюунхэрлэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлүүлж, тайланг аймгийн Сонгуулийн хороонд 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр хүргүүллээ.




Үндсэн мэдээлэл.

Дорнод аймгийн Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд 2 намын 7 нэр дэвшигч оролцсон байна.

Хүснэгт №1. Орон нутгийн ИТХ-ын нөхөн сонгуульд нэр дэвшигчид.

| д/д | Нам эвсэл бие даагчийн нэрс | Баянтүмэн суманд нэр дэвшигч | Хөлөнбуйр суманд нэр дэвшигч | Сэргэлэн суманд нэр дэвшигч |
|-----|-----------------------------|------------------------------|------------------------------|-----------------------------|
| 1 | Ардчилсан нам | 2 | 1 | - |
| 2 | Монгол ардын нам | 2 | 1 | 1 |
| | ДҮН | 4 | 2 | 1 |

Дүрслэл №1. Орон нутгийн ИТХ-ын нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн намын харьяалал.



Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд АН-аас 3 нэр дэвшигч, МАН-аас 4 нэр дэвшигч оролцсон байна. /Дүрслэл №1/

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны орлого, зардлын талаар.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т “Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны тухай хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ” гэж заасны дагуу Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон 2 намын 7 нэр дэвшигчээс 5 нэр дэвшигч данс нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Орон нутгийн ИТХ-ын нөхөн сонгуулийн зардлын данс нээлгээгүй нэр дэвшигчид.

| д/д | Нэр дэвшигчийн нэрс | Сумын нэрс | Намын нэрс |
|-----|---------------------|------------|------------|
| 1 | Т.Оюунжаргал | Баянтүмэн | МАН |
| 2 | Т.Сугаржав | Баянтүмэн | МАН |
| 3 | Г.Гантулга | Сэргэлэн | МАН |
| 4 | Ю.Цэпэлмаа | Хөлөнбуйр | АН |
| 5 | Г.Чинбат | Хөлөнбуйр | АН |



Дорнод аймгийн Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчээс орлого, зардлын тайлангаа ирүүлсэн 2 нам, 7 нэр дэвшигчийн зардлын дансанд орлого, зардлын гүйлгээ хийгдээгүй, мөнгөн болон мөнгөн бус хандив аваагүй байна.

Хүснэгт 3. Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны орлого.

| д/д | Нам, бие даагчийн нэрс | Нийт орлогын дүн | Үүнээс: Орлогын ангилал | | | | | |
|------------------|------------------------|------------------|-------------------------------------|-------------------------------|----------------------|-------------------|--------------------------------|-------------------|
| | | | Нам /эвслэс оруулсан мөнгөн хөрөнгө | Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө | Иргэний өгсөн хандив | | Хуулийн этгээдийн өгсөн хандив | |
| | | | | | Мөнгөн хандив | Мөнгөн бус хандив | Мөнгөн хандив | Мөнгөн бус хандив |
| 1 | Ардчилсан нам | - | - | - | - | - | - | - |
| 2 | Монгол Ардын нам | - | - | - | - | - | - | - |
| 3 | Т.Оюунжаргал | - | - | - | - | - | - | - |
| 4 | Т.Сугаржав | - | - | - | - | - | - | - |
| 5 | Г.Гантулга | - | - | - | - | - | - | - |
| 6 | Ю.Цэпэлмаа | - | - | - | - | - | - | - |
| 7 | Э.Батбаяр | - | - | - | - | - | - | - |
| 8 | Э.Бат-Ирээдүй | - | - | - | - | - | - | - |
| 9 | Г.Чинбат | - | - | - | - | - | - | - |
| Нийт орлогын дүн | | - | - | - | - | - | - | - |

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт **“Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.”** гэж заасны дагуу аймгийн АН, МАН-аас оролцсон 2 нэр дэвшигчийн зардлын дансны хуулга ирүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т **“Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ”** гэж заасны дагуу зардлын тайлангаа аймгийн АН 2022.09.01-ны өдрийн 09/05, МАН 2022.09.05-ны өдрийн 06 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт **“Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.”** гэж заасны дагуу Орон нутгийн ИТХ-ын нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив аваагүй байна.



ДҮГНЭЛТ:

1. Аудитын хуулийн этгээд нь Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон 4 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн гэж дүгнэсэн байна.
2. Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон 3 нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайландаа аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулаагүй байна.
3. Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон 5 нэр дэвшигч данс нээлгээгүй байна.
4. Баянтүмэн, Хөлөнбуйр, Сэргэлэн сумын ИТХ-ын нөхөн сонгуульд оролцсон 2 намын 7 нэр дэвшигчийн зардлын дансанд орлого, зардлын гүйлгээ хийгдээгүй, мөнгөн болон мөнгөн бус хандив аваагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн сонгуулийн хороонд:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль болон сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар нам, нэр дэвшигч, иргэдийн боловсролыг дээшлүүлэх талаар мэдээ, мэдээллийг хүргэж байх.
2. Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах, баталгаажуулах, орон нутгийн хэмжээнд нэгтгэж тайлагнах, тайланг хүргүүлэх, нийтэд мэдээлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/20

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх"-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын аудитын хоёрдугаар газарт болон аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (И.Сэмжидмаа)-д даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010087



Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын

Тамгын газрын 2-р байр, 1, 2 давхарт

Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207

И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn